



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Цэцэн-Уул сумын Цэцэрлэг 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: ЗАА-2022/150/СТА-ТШЗ

Цахим хуудас:
www.audit.mn
Улиастай сум
2022 он

Завхан аймаг дахь Төрийн Аудитын газрын
тэргүүлэх аудитор: Д.Бат-Ундраа
Утас: 99993365
Цахим хаяг: Bat-Undraa@audit.gov.mn

Ахлах аудитор : Г.Заяа
Утас:92038288
Цахим хаяг:zayag@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл.....	2
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	4
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	5
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	7
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	8
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	8
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан	10
3. Аудитын тайлан	
3.1 Ерөнхий зүйл	
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	14
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....	15
3.4 Материаллаг байдал.....	15
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга.....	Error! Bookmark not defined.
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	16
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг	17
3.8 Аудитын гол асуудал	17
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	17
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	17
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	17
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал	17
Анхаарах асуудал байхгүй.....	
4. Аудитын илрүүлэлт	18
4.1 Залруулсан алдаа.....	18
4.2 Төлбөрийн акт тогтоогоогүй.....	18
4.3 Албан шаардлага.....	18
4.4 Зөвлөмж.....	
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл.....	19

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар



**ЗАВХАН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

81090 Улиастай, Завхан аймаг
Утас/Факс: 7046-36-12

2022.02.25 № 1302/413
танай _____ -ны № _____ -т

ЦЭЦЭН-УУЛ СУМЫН
ХҮҮХДИЙН ЦЭЦЭРЛЭГИЙН
ЭРХЛЭГЧ Ж.НАРАНЖАРГАЛ-д

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Цэцэн-уул сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан алдаа, зөрчлийн үр нөлөөг эс тооцвол Цэцэн-уул сумын хүүхдийн цэцэрлэгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Цэцэн-уул сумын хүүхдийн цэцэрлэг нь 2021 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангаа 2021 оны 02 дугаар сарын 21-ны өдөр манай байгууллагад ирүүлсэн зөрчил нь (Төсвийн тухай хуулийн 8.9.1 дэх заалттай нийцээгүй) байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

013625460

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР  Д.БАТ-УНДРАА



2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2021 оны 12 сарын 31

Дансны код	Үзүүлэлт	Төгрөг	
		ЭХНИЙ ҮЛДЭГДЭЛ	ЭЦСИЙН ҮЛДЭГДЭЛ
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	43,591,008.01	44,392,029.54
27	АВЛАГА	259,866.01	3,151,778.54
32	НДШ-ийн авлага	139,071.01	2,520,353.35
33	ХАОАТ-ын авлага	-	10,630.19
35	Бусад зардлын тооцооны авлага	120,795.00	120,795.00
36	Бусад авлага	-	500,000.00
37	Байгууллагаас авах авлага	-	500,000.00
59	БАРАА МАТЕРИАЛ	43,331,142.00	41,240,251.00
60	Түүхий эд материал	4,946,000.00	5,578,400.00
61	Тусгай зориулалттай материал	3,854,000.00	3,854,000.00
62	Эм боох материал	1,092,000.00	1,724,400.00
65	Хангамжийн материал	38,385,142.00	35,661,851.00
66	Бичиг хэргийн материал	677,600.00	799,800.00
67	Аж ахуйн материал	3,200,380.00	3,532,900.00
69	Түлш шатах тослох материал	5,257,827.00	1,800,000.00
70	Барилгын засварын материал	1,590,000.00	2,290,000.00
71	Хүнсний материал	10,655,144.00	9,743,420.00
72	Бусад хангамжийн материал	17,004,191.00	17,495,731.00
85	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	113,896,925.47	124,429,618.50
105	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	113,896,925.47	124,429,618.50
107	Биет хөрөнгө	105,470,925.31	116,043,618.50
108	Барилга, байгууламж	103,535,914.23	103,535,914.23
109	Хуримтлагдсан элэгдэл	(16,803,642.88)	(18,801,657.76)
112	Машин, тоног төхөөрөмж	19,469,744.00	33,581,544.00
113	Хуримтлагдсан элэгдэл	(13,016,094.72)	(13,829,759.96)

114	Тавилга, аж ахуйн эд хогшил	30,340,936.22	31,088,936.22
115	Хуримтлагдсан элэгдэл	(20,202,939.55)	(21,678,366.24)
121	Бусад үндсэн хөрөнгө	2,639,910.12	2,639,910.12
122	Хуримтлагдсан элэгдэл	(2,639,910.12)	(2,639,910.12)
124	Номын фонд	2,147,008.01	2,147,008.01
125	Биет бус хөрөнгө	8,426,000.16	8,386,000.00
126	Програм хангамж	1,850,000.00	1,850,000.00
127	Хасагдуулга	(159,999.84)	(200,000.00)
128	Бусад биет бус хөрөнгө	6,736,000.00	6,736,000.00
136	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	157,487,933.48	168,821,648.04
213	ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ДҮН	157,487,933.48	168,821,648.04
214	Засгийн газрын хувь оролцоо	157,487,933.48	168,821,648.04
215	Засгийн газрын оруулсан капитал /ЗГСан/ орон нутгийн сан	60,133,555.30	60,133,555.30
216	Өмч: -Төрийн өмч	60,133,555.30	60,133,555.30
222	Хуримтлагдсан үр дүн	(7,494,019.53)	3,839,695.03
223	Өмнөх үеийн үр дүн	(18,835,013.48)	(7,494,019.53)
224	Тайлант үеийн үр дүн	11,340,993.95	11,333,714.56
226	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	104,848,397.71	104,848,397.71
230	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ДҮН	157,487,933.48	168,821,648.04

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2021 оны 12 сарын 31		Төгрөг	
Дансны код	ҮЗҮҮЛЭЛТ	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	263,202,576.00	264,308,878.00
76	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	4,699,000.00	5,989,540.00
77	Нийтлэг татварын бус орлого	4,699,000.00	5,989,540.00
81	Төсөвт байгууллагын өөрийн орлого	4,699,000.00	5,989,540.00
86	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	4,699,000.00	5,989,540.00
110	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	17,026,776.00	13,102,938.00

118	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	241,476,800.00	245,216,400.00
121	Нэмэлт санхүүжилтийн орлого	9,172,476.00	4,953,138.00
126	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	9,172,476.00	4,953,138.00
128	Орон нутгийн төсвөөс санхүүжих	7,854,300.00	8,149,800.00
129	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	7,854,300.00	8,149,800.00
146	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН (II)	251,861,582.05	252,975,163.44
147	УРСГАЛ ЗАРДАЛ	251,861,582.05	252,975,163.44
148	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	202,309,557.35	228,193,364.95
149	Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	158,876,859.00	175,591,003.50
150	Цалин	158,876,859.00	175,591,003.50
156	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	20,131,766.00	23,392,999.48
157	Тэтгэврийн даатгалын шимтгэл	13,689,603.00	16,359,904.48
158	Тэтгэмжийн даатгалын шимтгэл	1,610,540.00	1,758,273.00
159	ҮОМШ өвчний даатгалын шимтгэл	1,288,433.00	1,406,620.00
160	Ажилгүйдлийн даатгалын шимтгэл	322,108.00	351,654.00
161	Эрүүл мэндийн даатгалын хураамж	3,221,082.00	3,516,548.00
163	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	3,979,945.34	10,597,401.00
164	Гэрэл цахилгааны зардал	480,705.34	523,990.00
165	Түлш, халаалтын зардал	3,114,240.00	10,073,411.00
166	Цэвэр, бохир усны зардал	385,000.00	-
169	Хангамж, бараа материалын зардал	1,944,693.00	3,725,580.00
170	Бичиг хэргийн материал	193,200.00	860,800.00
171	Тээвэр, шатахууны зардал	915,633.00	385,000.00
172	Шуудан холбоо интернетийн төлбөр	510,000.00	595,000.00
173	Ном, хэвлэлийн зардал	-	44,000.00
176	Аж ахуйн материал худалдан авах зардал	325,860.00	1,840,780.00
180	Нормативт зардал	12,276,922.00	9,229,774.00

181	Эм	-	641,600.00
182	Хоол	12,276,922.00	8,588,174.00
184	Эд хогшил, урсгал засварын зардал	328,000.00	-
188	Урсгал засвар	328,000.00	-
189	Томилолт, зочны зардал	100,000.00	190,000.00
191	Дотоод томилолтын зардал	100,000.00	190,000.00
193	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамж	-	400,000.00
195	Аудит, баталгаажуулалт зэрэглэл тогтоох зардал	-	400,000.00
208	Бараа үйлчилгээний бусад зардал	4,671,372.01	5,066,606.97
210	Хичээл сургалт, үйлдвэрлэлийн дадлагын зардал	977,000.00	739,500.00
211	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	3,694,372.01	4,327,106.97
223	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	49,552,024.70	24,781,798.49
227	Бусад урсгал шилжүүлэг	9,172,476.00	4,953,138.00
234	Хөдөө ОН-т тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	9,172,476.00	4,953,138.00
236	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	40,379,548.70	19,828,660.49
239	Төвлөрүүлэх шилжүүлэг	40,379,548.70	19,828,660.49
267	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III=I-II)	11,340,993.95	11,333,714.56
287	НИЙТ ҮР ДҮН (VII=III+VI)	11,340,993.95	11,333,714.56

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2021 оны 12 сарын 31

Төгрөг

ҮЗҮҮЛЭЛТ	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан үр дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
2020 оны 1-р сарын 1-ээрх үлдэгдэл	53,397,555.30	14,398,151.28	(28,532,033.04)	39,263,673.54
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	53,397,555.30	14,398,151.28	(28,532,033.04)	39,263,673.54

Тайлант үеийн үр дүн /Цэвэр ашиг алдагдал/	-	-	(523,188.73)	(523,188.73)
2020 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	60,133,555.30	104,848,397.71	(7,494,019.53)	157,487,933.48
2020 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	60,133,555.30	104,848,397.71	(7,494,019.53)	157,487,933.48
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	60,133,555.30	104,848,397.71	(7,494,019.53)	157,487,933.48
Тайлант үеийн үр дүн /Цэвэр ашиг алдагдал/	-	-	11,333,714.56	11,333,714.56
2021 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	60,133,555.30	104,848,397.71	3,839,695.03	168,821,648.04

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2021 оны 12 сарын 31

Төгрөг

Дансны код	ҮЗҮҮЛЭЛТ	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	258,503,576.00	258,319,338.00
109	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	258,503,576.00	258,319,338.00
117	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	241,476,800.00	245,216,400.00
120	Нэмэлт санхүүжилтийн орлого	9,172,476.00	4,953,138.00
125	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	9,172,476.00	4,953,138.00
127	Орон нутгийн төсвөөс санхүүжих	7,854,300.00	8,149,800.00
128	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	7,854,300.00	8,149,800.00
145	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (II)	256,853,576.00	248,957,538.00
146	УРСГАЛ ЗАРДАЛ	256,853,576.00	248,957,538.00
147	БАРАА АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	207,301,551.30	224,175,739.51
148	Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	158,594,192.33	175,591,003.50
149	Үндсэн цалин	124,963,491.29	115,243,985.30

150	Нэмэгдэл	20,528,425.10	44,990,633.20
151	Унаа хоолны хөнгөлөлт	216,000.00	612,000.00
152	Үр дүнгийн урамшуулал	12,886,275.94	14,744,385.00
155	Ажил олгочоос нийгтийн даатгалд төлөх шимтгэл	20,553,503.63	25,784,912.01
156	Тэтгэврийн даатгалын шимтгэл	13,773,063.72	18,052,338.13
157	Тэтгэмжийн даатгалын шимтгэл	1,483,531.23	2,085,074.81
158	ҮОМШ өвчний даатгалын шимтгэл	1,043,556.30	1,505,999.64
159	Ажилгүйдлийн даатгалын шимтгэл	691,589.87	376,599.73
160	Эрүүл мэндийн даатгалын хураамж	3,561,762.51	3,764,899.70
162	Байр ашиглалтай холбоотой тогтмол зардал	7,083,705.34	7,404,574.00
163	Гэрэл цахилгааны зардал	480,705.34	523,990.00
164	Түлш, халаалтын зардал	6,218,000.00	6,615,584.00
165	Цэвэр, бохир усны зардал	385,000.00	265,000.00
168	Хангамж, бараа материалын зардал	3,315,200.00	3,187,300.00
169	Бичиг хэрэг	694,400.00	695,000.00
170	Тээвэр, шатахуун	485,000.00	885,000.00
171	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	510,000.00	595,000.00
172	Ном, хэвлэл	-	44,000.00
174	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,625,800.00	968,300.00
179	Нормативт зардал	16,308,950.00	9,890,450.00
180	Эм бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	2,540,000.00	1,434,000.00
181	Хоол, хүнс	12,248,950.00	7,411,450.00
182	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,520,000.00	1,045,000.00
183	Эд хогшил, урсгал засварын зардал	-	700,000.00
187	Урсгал засвар	-	700,000.00
188	Томилолт, зочны зардал	100,000.00	190,000.00
190	Дотоод албан томилолт	100,000.00	190,000.00
192	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	-	400,000.00

194	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	-	400,000.00
206	Бараа үйлчилгээний бусад зардал	1,346,000.00	1,027,500.00
208	Хичээл үйлдвэрлэлийн дадлаг хийх	1,346,000.00	1,027,500.00
219	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	49,552,024.70	24,781,798.49
223	Бусад урсгал шилжүүлэг	9,172,476.00	4,953,138.00
230	Хөдөө орон нутагт тогвортой ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	9,172,476.00	4,953,138.00
232	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	40,379,548.70	19,828,660.49
235	Төвлөрүүлэх шилжүүлэг	40,379,548.70	19,828,660.49
248	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	1,650,000.00	9,361,800.00
249	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-	-
259	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	1,650,000.00	9,361,800.00
260	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	1,650,000.00	9,361,800.00
261	Дотоод эх үүсвэрээр	1,650,000.00	9,361,800.00
269	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал /ТӨҮГ/	1,650,000.00	9,361,800.00
276	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	(1,650,000.00)	(9,361,800.00)
301	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
302	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2021 оны 12 сарын 31

Төгрөг

№	ҮЗҮҮЛЭЛТ	ТӨЛӨВЛӨГӨӨ	ГҮЙЦЭТГЭЛ	Дүн	Хувь
2	I. НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	255,508,500.00	233,537,539.51	21,970,960.49	91.4
3	УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН	255,508,500.00	233,537,539.51	17,970,960.49	91.4
4	Бараа, үйлчилгээний зардал	255,508,500.00	233,537,539.51	21,970,960.49	91.40
5	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	184,783,100.00	175,591,003.50	9,192,096.50	95.03

6	Үндсэн цалин	130,572,700.00	115,243,985.30	15,328,714.70	88.26
7	Нэмэгдэл	39,091,500.00	44,990,633.20	(5,899,133.20)	115.09
8	Унаа, болон бусад нөхөн олговор	1,125,000.00	612,000.00	513,000.00	54.40
9	Урамшуулал	13,993,900.00	14,744,385.00	(750,485.00)	105.36
11	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	24,945,800.00	25,784,912.01	(839,112.01)	103.36
12	Тэтгэврийн даатгал	17,554,400.00	18,052,338.13	(497,938.13)	102.84
13	Тэтгэмжийн даатгал	1,847,800.00	2,085,074.81	(237,274.81)	112.84
14	ҮОМШӨ ний даатгал	1,478,300.00	1,505,999.64	(27,699.64)	101.87
15	Ажилгүйдлийн даатгал	369,600.00	376,599.73	(6,999.73)	101.89
16	Эрүүл мэндийн даатгал	3,695,700.00	3,764,899.70	(69,199.70)	101.87
17	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	9,952,600.00	7,404,574.00	2,548,026.00	74.40
18	Гэрэл цахилгаан	2,000,000.00	523,990.00	1,476,010.00	26.20
19	Түлш, халаалт	6,680,100.00	6,615,584.00	64,516.00	99.03
20	Цэвэр, бохир ус	1,272,500.00	265,000.00	1,007,500.00	20.83
22	Хангамж, бараа материалын зардал	4,988,000.00	3,187,300.00	1,800,700.00	63.90
23	Бичиг хэрэг	695,700.00	695,000.00	700.00	99.90
24	Тээвэр (шатахуун)	1,914,000.00	885,000.00	1,029,000.00	46.24
25	Шуудан холбоо, интернэтийн төлбөр	700,000.00	595,000.00	105,000.00	85.00
26	Ном, хэвлэл	52,200.00	44,000.00	8,200.00	84.29

28	Бага үнэтэй, түргэн элэгдэх, аж ахуйн эд зүйлс	1,626,100.00	968,300.00	657,800.00	59.55
30	Нормативт зардал	27,451,900.00	9,890,450.00	17,561,450.00	36.03
31	Эм бэлдмэл, эмнэлэгийн хэрэгсэл	2,541,400.00	1,434,000.00	1,107,400.00	56.43
32	Хоол, хүнс	23,388,700.00	7,411,450.00	15,977,250.00	31.69
33	Нормын хувцас зөөлөн эдлэл	1,521,800.00	1,045,000.00	476,800.00	68.67
34	Эд хогшил худалдан авах	797,200.00	700,000.00	97,200.00	87.81
38	Урсгал засвар	797,200.00	700,000.00	97,200.00	87.81
39	Томилолт, зочны зардал	782,300.00	190,000.00	592,300.00	24.29
41	Дотоод албан томилолт	782,300.00	190,000.00	592,300.00	24.29
43	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр	469,600.00	400,000.00	69,600.00	85.18
45	Аудит, баталгаажуулалт зэрэглэл тогтоох зардал	469,600.00	400,000.00	69,600.00	85.18
53	Бараа үйлчилгээний бусад зардал	1,338,000.00	10,389,300.00	(9,051,300.00)	776.48
55	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,338,000.00	10,389,300.00	(9,051,300.00)	776.48
66	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	-	4,953,138.00	(4,953,138.00)	-
70	Бусад урсгал шилжүүлэг	-	4,953,138.00	(4,953,138.00)	-

77	Хөдөө ОН-т тогтвор суурьшилтай ажилласны тэтгэмж	-	4,953,138.00	(4,953,138.00)	-
97	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	255,562,300.00	258,319,338.00	(2,757,038.00)	101.08
98	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	244,812,500.00	245,216,400.00	(403,900.00)	100.16
101	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	244,812,500.00	245,216,400.00	(403,900.00)	100.16
103	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	10,749,800.00	8,149,800.00	2,600,000.00	75.81
104	Орон нутгийн төсвөөс	10,749,800.00	8,149,800.00	2,600,000.00	75.81
120	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	4,953,138.00	(4,953,138.00)	-
125	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажилагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	4,953,138.00	(4,953,138.00)	-
133	АЖИЛЛАГСДЫН ТОО	16.00	16.00	-	100.00
134	Удирдах ажилтан	1.00	1.00	-	100.00
135	Гүйцэтгэх ажилтан	4.00	4.00	-	100.00
136	Үйлчлэх ажилтан	8.00	8.00	-	100.00
137	Гэрээт ажилтан	3.00	3.00	-	100.00

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

2021 оны 12 сарын 31

Төгрөг

Код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (I)	4,953,138.00
	УРСГАЛ ЗАРДАЛЫН ДҮН	4,953,138.00
	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	4,953,138.00
	Бусад урсгал шилжүүлэг	4,953,138.00
	Хөдөө ОН-т тогтвор суурьшилтай ажилласны тэтгэмж	4,953,138.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	4,953,138.00
	Нэмэлт санхүүжилтийн орлого	4,953,138.00
	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	4,953,138.00

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Цэцэн-Уул сумын хүүхдийн цэцэрлэгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Завхан аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Г.Заяа, хяналтыг Завхан аймаг дахь Төрийн Аудитын газрын ахлах аудитор Б.Дагвасүрэн, дарга, тэргүүлэх аудитор Д.Бат-Ундраа нар хэрэгжүүлсэн.

Цэцэн-Уул сумын хүүхдийн цэцэрлэгийн сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Завхан аймаг дахь Төрийн Аудитын газарт 2022 оны 02 дугаар сарын 21-ний өдөр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Цэцэн-Уул сумын хүүхдийн цэцэрлэг нь Хүүхдийн хөгжлийг дэмжих суралцахад тулгарч буй бэрхшээлийг арилгах, бүх талын хамтын ажиллагаа, оролцоог хангаж, хичээл сургалтын үйл ажиллагааг үр дүнтэй зохион байгуулах зэрэг зорилтуудыг дэвшүүлэн ажиллаж байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөгүй байна гэж үзлээ.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Дотоод хяналт, дотоод аудитын нэгж хэлтэс байхгүй, үйл ажиллагааны заавар журам гаргаж мөрдөөгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудиторос шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Цэцэн-Уул сумын хүүхдийн цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт орлогыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшнийг 1.5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны нийт орлогын 267.6 сая төгрөгөөс 1.5 хувиар буюу 4.0 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувь буюу 3.0 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

/мянган төгрөг/			
Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Авлага	259.9	3,151.8	2,891.9

Бараа материал	43,331.1	41,240.3	-2,090.8
Үндсэн хөрөнгө	113,896.9	124,429.6	10,532.7
Нийт хөрөнгө	157,487.9	168,821.6	11,333.7
Өр төлбөр	0	0	0
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	157,487.9	168,821.6	11,333.7
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	157,487.9	168,821.6	11,333.7

Авлага дансны үлдэгдэл 2,891.9 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь төсвийн хэмнэлтийг төвлөрүүлээгүйгээс шалтгаалжээ.

Бараа материалын дансны үлдэгдэл 2,090.8 мянган төгрөгөөр буурсан нь бараа материалын үлдэгдлээс зарцуулсантай холбоотой байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 10,532.7 мянган төгрөгөөр өссөн нь хандиваар 5,498.0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө нэмэгдэж, 9,361.8 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө худалдаж авсан зэрэгтэй холбоотой байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 11,333.7 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүн өссөнтэй холбоотой байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 244,812.5 мянган төгрөгийн, орон нутгийн төсвөөс 10,749.8 мянган төгрөгийн, нийт 255,562.3 мянган төгрөгийн санхүүжилт авахаар тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 245,216.4 мянган төгрөгийн, орон нутгийн төсвөөс 8,149.8 мянган төгрөгийн, нийт 253,366.2 мянган төгрөгийн санхүүжилт авч, урсгал үйл ажиллагаанд 233,537.5 мянган төгрөгийг зарцуулан, 19,828.7 мянган төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлсэн байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

2021 онд нэмэлт санхүүжилтээр 4,953.1 мянган төгрөгийг бүрдүүлэн тэтгэмжид зарцуулсан байна.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Төсвийн хэмнэлтийг төвлөрүүлэлгүй 2,520.4 мянган төгрөгийн авлага үүсгэсэн, Сумын Засаг дарга цэцэрлэгийн эрхлэгчид 434.1 мянган төгрөгийн ур чадварын нэмэгдлийг үр дүнгийн урамшуулал олгосон шалгуур үзүүлэлтээр дүгнэж холбогдох журмыг зөрчсөн, санхүүгийн тайлан гаргахдаа 2,600.0 мянган төгрөгийн орлогыг сумын Төрийн сантай тулгаагүй байна.

3.8 Аудитын гол асуудал

Тайлант онд 774.0 мянган төгрөгийн худалдан авалтын и-баримтыг бүрдүүлээгүй, төсвийн хэмнэлтийг төвлөрүүлэлгүй 2,520.4 мянган төгрөгийн авлага үүсгэсэн, 1,469.9 мянган төгрөгийн зардлыг өглөгийн дансаар дамжуулан бүртгээгүй байна.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны хэрэгжилтийг программаар шалгахад тайлант хугацаанд оруулбал зохих 22 мэдээллээс 19 мэдээллийг байршуулан, доорх 3 мэдээллийг байршуулаагүй байна.

- ✓ 3,151.8 мянган төгрөгийн авлагын мэдээлэл, үүсгэсэн шийдвэр
- ✓ 8,711.8 мянган төгрөгийн худалдан авалтын мэдээлэл,
- ✓ 30,363.8 мянган төгрөгийн орлогын мэдээлэл,

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй байна гэж дүгнэлээ.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны аудитаар шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг сайжруулах талаар өгөгдсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй, уг зөрчлийг давтан гаргасан байгааг анхаарч ажиллах шаардлагатай байна.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Бараа материал шинжтэй хөрөнгийг үндсэн хөрөнгөд бүртгэсэн, Сумын Засаг дарга цэцэрлэгийн эрхлэгчид 434.1 мянган төгрөгийн ур чадварын нэмэгдлийг үр дүнгийн урамшуулал олгодог шалгуур үзүүлэлтээр дүгнэж олгосон нь холбогдох журмыг зөрчсөн байна. Эдгээр зөрчлийг хэрхэн залруулсныг шалгана.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 49,591.7 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 2,600.0 мянган төгрөгийн алдааг залруулж, 46,991.7 мянган төгрөгийн зөрчилд зөвлөмж хүргүүлсэн.

4.1 Залруулсан алдаа

Мөнгөн гүйлгээний тайланд 2,600.0 мянган төгрөгийн залруулга хийгдсэн.

4.2 Төлбөрийн акт тогтоогоогүй

4.3 Албан шаардлага хүргүүлээгүй

4.3 Зөвлөмж

1. Хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой асуудал

1.1. Илрүүлэлт:

1. Шилэн дансны хэрэгжилтийг программаар шалгахад тайлант хугацаанд оруулбал зохих 22 мэдээллээс 19 мэдээллийг байршуулан, 42,227.4 мянган төгрөгийн 3 мэдээллийг байршуулаагүй байгаа нь Шилэн дансны тухай хуулийн 6.1.2; 6.1.4; 6.1.5; 6.4.4; 6.4.5 дахь заалтуудад заасан мэдээллийг шилэн дансны мэдээллийн цахим системд байршуулах гэж заасныг зөрчсөн байна.

1.2. Өгсөн зөвлөмж:

1. Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг ханган ажиллаж, мэдээллийг хугацаанд нь үнэн зөв байршуулж хэвших

2. Нягтлан бодох бүртгэл, тайлагналтай холбоотой асуудал

2.1.Илрүүлэлт:

- ✓ 774.0 мянган төгрөгийн худалдан авалтын и-баримтыг бүрдүүлээгүй;
- ✓ Төсвийн хэмнэлтийг дээд шатны төсвийн захирагчийн дансанд төвлөрүүлэлгүй 2,520.4 мянган төгрөгийн авлага үүсгэсэн;
- ✓ 1,469.9 мянган төгрөгийн зардлыг өглөгийн дансаар дамжуулан бүртгээгүй;

1.3. Өгсөн зөвлөмж:

1. Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.7-т "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно"; Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 14.3-т "Албан татвар суутган төлөгч хоорондын бараа борлуулсан, ажил гүйцэтгэсэн, үйлчилгээ үзүүлсэн тухай бүрд төлбөрийн баримт олгох бөгөөд уг баримтуудыг дангаар,

эсхүл хамтатган нэмэгдсэн өртгийн албан татварын падаан үйлдэнэ" гэж заасныг хэрэгжүүлж ажиллах;

2. Төсвийн тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.2-д "Зарцуулах эрх нь дараагийн төсвийн жилд дамжсан, энэ хуулийн 43.1.3-т зааснаас бусад төсвийн нийт дүн нь төсвийн ерөнхийлөн захирагчийн тухайн жилийн төсвийн гурван хувиас хэтрэхгүй бөгөөд түүнээс давсан хэсгийг тухайн шатны төсвийн ерөнхий дансанд татан төвлөрүүлнэ" гэж заасныг хэрэгжүүлэх;
3. Зардлыг өглөгийн дансаар дамжуулан бүртгэж хэвших;

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1.	Цэцэн-Уул сумын хүүхдийн цэцэрлэг	4	49,591.7	1	2,600.0					3	46,991.7